

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 08 ДУГААР ХУРАЛ**

2016 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 14 цаг 25 минутад эхэлж, 15 цаг 20 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 55 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Ховд аймгийн Ногоон хөгжлийн хөтөлбөрийн төсөл хэлэлцэх тухай	Ховд аймгийн Ногоон хөгжлийн хөтөлбөрийн төслийг дэмжиж, гарсан саналыг тусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Х.Баасанхүү, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга З.Лхамхүү нарт үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 09 ДҮГЭЭР ХУРАЛ**

2016 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 09 цаг 30 минутад эхэлж, 10 цаг 05 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 35 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний дүнгийн талаарх танилцуулга	Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний дүнгийн талаарх танилцуулгыг санал нэгтэй дэмжиж хугацаанд нь Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газарт хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний тасгийн мэргэжилтэн Б.Гантөмөрт үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 10 ДУГААР ХУРАЛ**

2016 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 10 цаг 30 минутад эхэлж, 11 цаг 30 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 60 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Орон нутгийн болон орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн төсвийн байгууллагуудын 2017 оны төсвийн төсөл, 2018-2019 оны дунд хугацааны төсөөлөлийн тухай	1.Залуучуудын соёл спортын цогцолбор гэснийг Залуучуудын соёлын цогцолбор гэж өөрчлөх 2.Аймгийн Хөгжимт драмын театр шинээр барих гэснийг хасаж, их засвар хийхээр өөрчлөх 3.Дөргөн сумын усыг 11 км-ээс татахад зардал тусгах 4.Эрдэнэбүрэний УЦСтанцын 110 мвт гэснийг 64 мвт гэж засварлах 5.Цамбагарав, Магсаржав, Рашаант багт дахин төлөвлөлтийн ТЭЗҮ боловсруулах зэрэг тус тус саналуудыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга П.Амгаланбаатарт үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР